



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/364

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 19 дүгээр зүйлийн 19.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын залуучуудын холбооноос зохион байгуулж буй Хангайн бүсийн бүтцийн бүх байгууллагуудын “Оролцоогоороо манлайлна” залуучуудын чуулга уулзалтыг Арвайхээр суманд 2024 оны 05 дугаар сарын 08-аас 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулах зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0743

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар
сарын 07-ны өдрийн 11301 дугаар
захирамжийн хавсралт



ХАНГАЙН БҮСИЙН БҮТЦИЙН БҮХ БАЙГУУЛЛАГУУДЫН “ОРОЛЦООГООРОО
МАНАЛАЙЛНА” ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Үйл ажиллагааны зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Баннер (хулдаасан хэвлэл)	Мк2	15	20,000	300,000
2	Стенд (стикер хэвлэл)	Ширхэг	5	100,000	500,000
3	Сургалтын танхимын түрээс	Ширхэг	2	475,000	950,000
4	Цайны материал	Ширхэг	350	10,000	3,500,000
5	Мандат	Ширхэг	350	5,000	1,750,000
Нийт					7,000,000

-оОо-